

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
Ч.НЯМГЭРЭЛИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт”							
1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж ажиллалаа. ХНХЯ болон НДЕГ-аас ирсэн нийт 58 албан бичгийг газрын албан хаагчдад 7 хоног бүрийн Даваа гаригийн сонсголоор танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2024.01.01-2024.06.15	100%
2	Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн	-	Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж	2024 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой иргэн, аж ахуй нэгж байгууллагаас нийт 47 өргөдөл хүсэлт ирснээс төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн дагуу 42 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж илэрсэн төлбөр зөрчилд	2024.03.14-2024.06.10	

	шалгалтын ажлыг зохион байгуулах.	төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана.		холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	15,228,159.46 төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоосноос 13,497,992.26 төгрөгийг барагдуулж актын биелэлт 88,6%-тай байна. Нийгмийн даатгалын газрын даргын баталсан удирдамжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өндөртэй 13 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах гэрээг хийсэн бөгөөд гэрээний хугацаанд 287,780,900 төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна.		
3	Арга хэмжээ 4.1.2. ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Тайлант хугацаанд иргэд, байгууллагаас сайн дурын даатгалын залруулга хийх хүсэлт 59, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх хүсэлт 36, тэтгэвэр дахин хянуулах хүсэлт 38, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 42, бусад шалтгаанаар 26 нийт 201 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлсэн 176, шийдвэрлэлт 87,5%-тай байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу иргэдээс тэтгэвэр тогтоолгох хүсэлт 474, тэтгэмж тогтоолгох хүсэлт 1635 ирж 2094 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 118-н тэтгэврийн өргөдөл хуулийн үндэслэл хангахгүй шалтгааны улмаас буцаагдсан байна. Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах	2024.01.01-2024.06.10	94,3%

					төвд иргэд даатгуулагчаас 14, НДЕГ-ын "Иргэд олон нийттэй харилцах 311131 утсанд 42, нийт 56 өргөдөл гомдол гаргасан. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлт 100%, нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 94,3 хувьтай байна.		
4	Арга хэмжээ 4.1.4 Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах	Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна.	НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоондоо багтаан 3 хэлтсийн зохион байгуулалтаар 47 байцаагч, 6 үйлчилгээний ажилтантай, "Орон тооны бус төлөөлөгчийн ажиллах журам"-ын дагуу батлагдсан төсвийн хүрээнд 1 орон тооны бус төлөөлөгчтэй нийт 54 орон тоотой ажиллахаас тайлант онд 48 албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны сул орон тоог нөхөх зарыг Төмөрбулаг сум-2, Улаан-Уул сум 2023 онд 2, 2024 онд 2, нийт 4 удаа, Рэнчинлхүмбэ сум-1, Цагааннуур сум-1, нийт 4 сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тоог зарлуулах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.Тариалан сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тооны захиалгыг 2023 онд ТАСЗ-д 4 удаа хүргүүлж 2024 оны 01 дүгээр сард салбар зөвлөлийн тогтоолын дагуу Тариалан сумын байцаагчийг томиллоо.Албан тушаалын тодорхойлолт батлагдаж ирээгүйтэй холбоотой сул орон тоон дээр тусгай	2024.01.01-2024.06.10	100%

					шалгалт хүлээгдэж байна.		
5	Арга хэмжээ 4.1.6 Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна.	Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 29 албан хаагчид 186245400 төгрөгийн урамшуулал, Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэрэг олгох журмын дагуу 20 байцаагчид зөвлөх болон тэргүүлэх зэргийн нэмэгдэл, мөн орон нутагт ажилласны нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт албан хаагчдад олгож эхлээд байна. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад тус газрын дарга, нэгжийн дарга нийт 3 албан тушаалтан суралцаж байна.	2024.01.01-2024.06.10	100%
6	Арга хэмжээ 4.1.7 Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	Хэлтсийн ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна.	Прокурорын газрын зөрчлийн ахлах прокурор С.Батсүх, зөрчлийн прокурор н.Батзолбоо нар 2024 оны 04-р сарын 05-ны өдөр "Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих" сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар нийт сумдын байцаагч нарыг цахимаар хамрууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Соёмбо танхимд Авлигатай тэмцэх газрын комиссар н.Амартүвшин Авлигын хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалтанд газрын эрх бүхий албан тушаалтнууд хамрагдаж авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	2024.01.01-2024.12.05	100%

			сургалтыг зохион байгуулах.		арга хэмжээг авч ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-ны цахим сургалтад газрын албан хаагчид бүрэн хамрагдлаа. Байгууллагын 27 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна.		
Зорилт 2. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
1.	Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацааны төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхолын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх				Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийг чанд мөрдөж ажилласан болно.		100%
2.	Холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл тайлбарыг хуулийн хугацаанд мэдүүлэх				Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь цахим системд мэдүүлж ажиллалаа.		100%
3.	Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг Төрийн байгууллагын цахим сүлжээ				Цагийн бүртгэлийг Төрийн байгууллагын цахим систем ERP-д бүртгүүлж хэвшсэн.		100%

	ERP-д бүртгүүлэх						
4.	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг хос бичгээр гаргаж ирүүлэх				Хүлээгдэж буй гүйцэтгэл		
5.	НДЕГазар болон Хөвсгөл аймгийн нэрлэсэн жилийн хүрээнд гарсан газрын төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж ирүүлэх				Тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж хэлтсийн даргад хүргүүлэн ажилласан.	2024.01.02-2024.06.10	100%
6.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдөж, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах				Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргаагүй болно.	2024.01.02-2024.06.10	100%

Зорилт 3: Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг хэрэгжүүлж ажиллах зорилтын хүрээнд

1	НДЕГ, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хүний нөөцтэй холбоотой аливаа асуудлыг зохион байгуулах, шийдвэрлэх, бүртгэх, тайлагнах Хүний нөөцтэй холбоотой аливаа асуудлаар даргын тушаал, шийдвэр, гэрээ хэлэлцээрийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, батлуулах, шийдвэрлүүлэх, мөрдүүлэх				Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн үүрэг даалгавар, албан бичгийн дагуу хүний нөөцтэй холбоотой судалгаа, тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Тайлант онд хүний нөөцтэй холбоотой 72 тушаал шийдвэрийг боловсруулан, батлуулж ажилласан байна.	2024.01.02-2024.06.10	100%
2	Шагнуулах ажилтнуудын				Журмын дагуу болзол хангасан	2024.01.	100%

	материалыг хэлтсийн даргад танилцуулан, бэлтгэж, холбогдох газарт хүргүүлэх				байцаагч ажилтнуудын шагналын материалыг тухай бүр холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа. Төрийн дээд одон медальд 7, Засгийн газрын шагналд 3, салбарын шагналд 3 нийт 13 албан хаагчдын шагналын материалыг хүргүүлсэн байна. Хүний нөөц, хуулийн мэргэжилтний түр эзгүй байх хугацаанд төрийн дээд одон медальд 10, салбарын шагналд 4, аймгийн шагналд 6 албан хаагчийн материалыг хүргүүлэн, шийдвэрлүүлсэн байна.	02-2024.12.05	
3	Төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх, баяжилтыг тухай бүр хийх				Төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөн баяжилтыг хийн хадгалж байна.	2024.01.02-2024.06.10	100%
Зорилт 4: Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр							
1	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин	2023 онд 413 объектод хяналт шалтгалт хийж, 1166 зөрчил илэрүүлж, 193 албан шаардлага гаргасан.	Шалгалтад хамрагдсан объектод хууль сахин мөрдөлтийн түвшинг +10%, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт 100%, илэрсэн зөрчлийг 100% арилгуулах, объектын эрсдэлийн түвшинг	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн байцаагч нартай хамтран зам тээврийн үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл АЗЗА, Хөвсгөл зам ХХК-д төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтын танилцуулга болон тоон мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан байна.	2024.07.01-2024.12.05	100%

		буурсан объектын тоо, хувь		бууруулна.			
2	Удирдах байгууллага, албан тушаалтанаас гаргасан шийдвэрийн хүрээнд хяналт шалгалт гүйцэтгэх	Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалты тоо, хувиар	Суурь үзүүлэлт байхгүй.	Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг гүйцэтгэж буй Энх бизнес өгөөмж ХХК-ийн үйл ажиллагаанд нийгмийн хамгааллын салбарын хяналтаар урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, гарсан зөрчилд Зөрчлийн хуулийн дагуу 200,000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.		
3	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Акт, Албан шаардлагын биелэлт (тоо, хувь) Зөрчил арилгалт (хувь)	Суурь үзүүлэлт байхгүй.	Албан шаардлагаар өгсөн үүрэг, даалгаварын биелэлтийг дүгнэж, тайлагнах	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгдээгүй.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. SICOS программд Арбулаг, Цагааннуур сумдын аж ахуйн нэгж байгууллагын 2024 оны 1-3 сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг нягтлан бодогч нартай тооцоо нийлж, тулган баталгаажуулах			Сумдын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан бүрэн баталгаажсан байна.	Арбулаг, Цагааннуур сумдын аж ахуйн нэгж байгууллагын 2024 оны 1-3 сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг SICOS программд тулган баталгаажуулж ажилласан. Цагааннуур сумын Төрийн банкны тайлангийн 2023 оны эцсийн үлдэгдэл татагдахгүй байгааг Мэдээллийн технологийн	2024.01.02-2024.03.20	100%

					мэргэжилтнээр дамжуулан МТТөвд хүргүүлсэн.		
2.	Хариуцсан сумдын тэтгэмжүүдийг бодож дуусгах			Тэтгэмжийг бүрэн бодож олгосон байна.	Алаг-Эрдэнэ сумын иргэн даатгуулагчаас ирүүлсэн 5 тэтгэмжийг бодож хуулийн хугацаанд санхүүд шилжүүлэн ажиллалаа.	2024.01.02-2024.03.20	100%
3	Сангийн тайлан гаргахад ХЧА тэтгэврийн хувь хугацааг өөрчлөх				Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч Хатгал тосгоны 7 Түнэл сумын 9, нийт 16 тэтгэвэр авагчийн хувь хугацааг өөрчлөн SICOS программд оруулсан.		100%
4	Тайлантай холбоотойгоор 326 нас барсан иргэний мэдээллийг программаас шүүж гаргах				Нас барсан 326 иргэний мэдээллийг SICOS программд тулган шалгаж гарсан зөрчлийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга Б.Номинд илтгэх хуудсаар жагсаалтын хамт хүлээлгэн өгсөн болно.		100%
5	Албан хаагчдын шагналын материалыг холбогдох газруудад хүргүүлэх				Хүний нөөц, хуулийн мэргэжилтний түр эзгүй байх хугацаанд төрийн дээд одон медальд 10, салбарын шагналд 4, аймгийн шагналд 6 албан хаагчийн материалыг хүргүүлэн, шийдвэрлүүлсэн байна.		100%
6	Аж ахуйн нэгж байгууллагын эрсдлийг үнэлэх				Shilenkhyanalт.gov.mn хяналтын программд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 596 аж ахуйн нэгж байгууллагын эрсдлийг үнэлэн хуулийн хугацаанд илгээсэн.		100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1		2	3	4	5	6	7

1.	Монгол бичгээр тайлан бичих арга зүйд суралцах			Хос бичгээр мэдээ тайлан гаргах чадварт суралцсан байна.	Монгол бичгийг бие даан судлаж, Улаанбаатар CMS фондыг компьютерт суулган бичих арга зүйд суралцаж байна.	2024.01.02-2024.12.05	100%
2	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамрагдсан байх			Сургалтад бүрэн хамрагдаж мэдээ мэдээллээр хангагдсан байна.	2024 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 25 удаа Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 вебинар сургалтад цахимаар хамрагдсан байна.	2024.01.02-2024.12.05	100%
3	Арга хэмжээ 3. Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх			Сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны тухай хуульд заасанчлан Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдахаар хүсэлт гаргасан бөгөөд хичээл 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэхээр Сургалтын гэрээг хийсэн болно.	2024.01.02-2024.12.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн хамгааллын хяналтын
улсын байцаагч
(Албан тушаал)

Ч.Нямгэрэл / /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)